

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИХ ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ЕРӨНХИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/-ноос зохицуулалттай зах зээлд арилжих үүсмэл санхүүгийн хэрэгсэл /цаашид “үүсмэл санхүүгийн хэрэгсэл” гэх/-ийн арилжаанд оролцогчдын эрх үүргийг тодорхойлох, оролцогчдод тавигдах ерөнхий шаардлага, шалгуурыг тогтоох, үүсмэл санхүүгийн хэрэгслийг Хорооны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбоотой үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлийн харилцааг зохицуулахад оршино.

1.2. Биржийн бус зах зээлд арилжих үүсмэл санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой үйл ажиллагаа энэхүү журмаар зохицуулагдахгүй.

1.3. Зохицуулалттай зах зээлд арилжих Хороонд бүртгүүлээгүй аливаа үүсмэл санхүүгийн хэрэгслийг нийтэд сурталчлах, арилжихыг хориглоно.

1.4. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах нэмэлт шаардлагыг Хорооноос баталсан журмаар зохицуулна.

Хоёр. Нэр томъёо

2.1. Энэхүү журмын дор дурдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

2.1.1. “зохицуулалттай зах зээл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.2-т заасан харилцааг;

2.1.2. “суурь хэрэгсэл” гэж арилжаа эрхлэх байгууллагаас тодорхойлсон үнэт цаас, индекс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бараа бүтээгдэхүүн болон бусад хэрэгслийг;

2.1.3. “үүсмэл санхүүгийн хэрэгсэл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.7-д заасан санхүүгийн хэрэгслийг;

2.1.4. “опцион гэрээ” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.10-т заасан үүсмэл санхүүгийн хэрэгслийг;

2.1.5. “фьючерсийн гэрээ” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.11-т заасан үүсмэл санхүүгийн хэрэгслийг;

2.1.7. “үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа” гэж дараах үйл ажиллагааг хэлнэ:

2.1.7.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн брокерийн;

2.1.7.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийн дилерийн;

2.1.7.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэх;

2.1.7.4. үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны;

2.1.7.5. Хорооноос үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлтэй холбоотой ажил үйлчилгээ гэж үзсэн бусад үйл ажиллагаа;

2.1.8. “үүсмэл санхүүгийн хэрэгслийн брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж /цаашид “брокер” гэх/ үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор Хорооноос тусгайлан тавьсан нөхцөл, шаардлага, шалгуурыг хангасан этгээдийг;

2.1.9. “үүсмэл санхүүгийн хэрэгслийн дилерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж /цаашид “дилер” гэх/ үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор Хорооноос тусгайлан тавьсан нөхцөл, шаардлага, шалгуурыг хангасан этгээдийг;

2.1.10. “үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэх этгээд” гэж /цаашид “арилжаа эрхлэх байгууллага” гэх/ үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор Хорооноос тусгайлан тавьсан нөхцөл, шаардлага, шалгуурыг хангасан, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47.1-д заасан үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг;

2.1.11. “үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны үйл ажиллагаа эрхлэх этгээд” /цаашид “тооцооны байгууллага” гэх/ гэж үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор Хорооноос тусгайлан тавьсан нөхцөл, шаардлага, шалгуурыг хангасан, худалдан авагч бүрийн өмнө худалдагч, худалдагч бүрийн өмнө худалдан авагч болж, оролцогчдын харилцан хүлээсэн үүргийг олон талын үр дүнгээр тодорхойлж, төлбөрийн эрсдэлийг системийн хэмжээнд удирдах үүрэг хүлээсэн тооцооны үйл ажиллагаа эрхлэх этгээдийг;

2.1.12. “үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжих” гэж үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ байгуулахыг;

2.1.13. “үүсмэл санхүүгийн хэрэгслийн позиц” гэж гэрээний талуудын хооронд үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаагаар үүсч буй эрх, үүргийг;

2.1.14. “үүсмэл санхүүгийн хэрэгслийн позицийг хаах” гэж позицийг тооцооны байгууллагын журамд заасны дагуу тэнцүү, эсрэг нийлүүлэлт хийн баланслах замаар үүргээс чөлөөлөгдөх эсхүл эрхийг цуцлахыг;

2.1.15. “анхдагч маржин” гэж үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг эхлүүлэхэд шаардагдах хөрөнгийг;

2.1.16. “төлбөрийн баталгааны сан” гэж тооцооны байгууллагын гишүүний төлбөрийн чадваргүйгээс үүссэн алдагдлыг тухайн гишүүний байршуулсан маржингаар бүрэн төлж барагдуулж чадахгүй байхаас сэргийлж хуримтлуулсан санг;

2.1.17. “үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээ” /цаашид “үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ” гэх/ гэж арилжаа эрхлэх байгууллагаас батлан гаргасан, стандарт нөхцөлтэй гэрээг.

2.1.18. “биетээр хүргэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ” гэж суурь хэрэгслийг гэрээнд заасан хүргэлтийн хугацаанд хүргэхээр заасан нөхцөлтэй гэрээг;

2.1.19. “бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ” гэж суурь хэрэгслийг гэрээний хугацаа дуусахад биетээр хүргэхийн оронд тухайн позицийг хаах замаар бэлэн мөнгөөр тооцоо хийхийг.

Гурав. Хороо, арилжаа эрхлэх байгууллага, тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллагын эрх, үүрэг

3.1. Хороо нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлд дараах эрх, үүрэгтэй:

3.1.1. Хороо нь зах зээлийн эрсдэлийг бууруулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дагаж мөрдөх дүрэм, журмыг батлан, мөрдүүлэх үүрэгтэй.

3.1.2. Хороо нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх үүрэгтэй.

3.1.3. Хороо нь арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээг бүртгүүлэх хүсэлтийг хянах, түүнийг бүртгэх, бүртгэлтэй үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээний нөхцөл, тавигдах шаардлагуудад өөрчлөлт оруулах, бүртгэлтэй үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээг арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу бүртгэлээс хасна.

3.1.4. Хороо нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлагатай үед үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдэд нэмэлт нөхцөл, шаардлага, шалгуурыг тогтоож болно.

3.1.5. Хороо нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдээс тайлан, мэдээ, мэдээллийг тусгайлан заасан хугацаанд, эсхүл Хорооноос шаардлагатай гэж үзсэн үед ирүүлэхийг шаардах эрхтэй. Хороо нь ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэлтэй холбоотойгоор гарсан нэмэлт асуулга, тодруулгыг мөн шаардаж болно.

3.1.6. Хороо нь эрсдэлийг бууруулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хүлээлгэсэн хариуцлагын талаарх мэдээллийг ил тод болгох үүрэгтэй.

3.2. Арилжаа эрхлэх байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлд дараах эрх, үүрэгтэй:

3.2.1. Арилжаа эрхлэх байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийг нийтэд санал болгон худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ хэлцэл байгуулах нөхцлийг бүрдүүлж, үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг зохион байгуулах үүрэгтэй.

3.2.2. Арилжаа эрхлэх байгууллага нь Хорооноос тогтоосон үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, шалгуурыг хангаж, зөвшөөрөл авсны үндсэн дээр үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэх үйл ажиллагааг явуулна.

3.2.3. Арилжаа эрхлэх байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн шинэ стандарт гэрээг судалгаа, шинжилгээний үндсэн дээр боловсруулж, Хороонд бүртгүүлэхээр холбогдох баримт бичиг, материалын хамт ирүүлэх үүрэгтэй.

3.2.4. Арилжаа эрхлэх байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд арилжих стандарт гэрээний нөхцөл, шаардлагыг тогтоох, хяналт тавих, мөрдүүлэх үүрэгтэй.

3.2.5. Арилжаа эрхлэх байгууллага нь брокер, дилерийн үйл ажиллагаанд тодорхой нэмэлт нөхцөл, шаардлага, шалгуурыг тавих эрхтэй.

3.2.6. Арилжаа эрхлэх байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Хороотой зөвшилцсөний үндсэн дээр дараах арга хэмжээг авах эрхтэй:

3.2.6.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн нээлттэй позицыг хаах, шилжүүлэх;

3.2.6.2. зах зээлийн оролцогч бусад этгээдэд нэмэлт маржингийн шаардлагыг тавих.

3.2.7. Арилжаа эрхлэх байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг урвуулан ашиглах, үнэ ханшийг гажуудуулах, төлбөр тооцооны системд доголдол үүсэхээс сэргийлэх зорилгоор арилжааны бодит цагийн хяналт тавих, зах зээлийн тандалт судалгаа хийх үүрэгтэй.

3.2.8. Арилжаа эрхлэх байгууллага нь нэг этгээдийн эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж болох үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний үнийн дүн, тоо хэмжээнд шаардлагатай тохиолдолд хязгаарлалт тогтоож болно.

3.2.9. Арилжаа эрхлэх байгууллага нь Хороо, үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээд, олон нийтийг дараах мэдээллээр хангах үүрэгтэй:

3.2.9.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээний нөхцөл;

3.2.9.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжаа эрхлэх байгууллагаар дамжин арилжихтай холбоотой дүрэм, журам, заавар;

3.2.9.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн үйл ажиллагаа, арилжааны програм хангамж, төлбөр, тооцоо гүйцэтгэх байгууллагын талаарх мэдээлэл.

3.2.10. Арилжаа эрхлэх байгууллага нь ашиг сонирхлын зөрчил үүссэн, зах зээлийг урвуулан ашигласан талаар нотлох баримт гаргах чиглэлээр арилжааны бүхий л мэдээллийг аюулгүй хадгалах, бүртгэл хөтлөх үүрэгтэй.

3.2.11. Арилжаа эрхлэх байгууллага нь гэрээнд заасан хүргэлт хийх хугацаанд биетээр хүргэх суурь хэрэгслийн нийлүүлэлтийн тоо хэмжээг тооцоолж гаргана.

3.3. Тооцооны байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлд дараах эрх, үүрэгтэй:

3.3.1. Тооцооны байгууллага нь арилжаа эрхлэх байгууллагын бүтцэд, эсхүл тусдаа бие даасан хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болно.

3.3.2. Тооцооны байгууллага нь Хорооноос үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах нөхцөл, шаардлага, шалгуурыг хангаж зөвшөөрөл авсны үндсэн дээр үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны үйл ажиллагааг эрхэлнэ.

3.3.3. Тооцооны байгууллага нь зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн системийн эрсдэлийг урьдчилан тооцож, авч хэрэгжүүлэх арга хэмжээг санал дүгнэлтийн хамт Хороонд мэдэгдэх үүрэгтэй.

3.3.4. Тооцооны байгууллага нь эрсдэлийг иж бүрэн удирдах эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх бөгөөд тооцооны байгууллага болон тооцооны гишүүний позицыг өдөр бүр зах зээлийн үнээр дахин үнэлж, шинэчлэн тооцоолох, хянах, шаардлагатай тохиолдолд хязгаарлалт тавих үүрэгтэй.

3.3.5. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн төлбөр тооцооны системийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тооцооны байгууллага нь дараах арга хэмжээг авах эрхтэй:

3.3.5.1. тооцооны гишүүнийг нэмэлт барьцаа байршуулахыг шаардах;

3.3.5.2. тооцооны гишүүн, эсхүл түүний харилцагчийн эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэгслийн позицитай дээд хязгаарлалтанд өөрчлөлт оруулах;

3.3.5.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн позицитай хаах.

3.3.6. Тооцооны байгууллага нь төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор тооцооны гишүүн эсхүл харилцагчаас маржингийн болон бусад хэлбэрээр барьцаа байршуулахыг шаардах эрхтэй.

3.3.7. Тооцооны байгууллага нь тооцооны гишүүн эсхүл харилцагчийн маржин хэлбэрээр байршуулсан барьцаа хөрөнгийг харилцагч тус бүрээр, өөрийн хөрөнгөөс

тусдаа хадгалах бөгөөд зөвхөн тухайн тооцооны гишүүн, харилцагчийн төлбөрийн үүргийг баталгаажуулах, гүйцэтгэхэд ашиглана.

3.3.8. Тооцооны байгууллага нь маржинг тооцоолох аргачлалд тогтмол хугацаанд хяналт тавьж, эрсдэлд суурилсан олон улсын аргачлалыг нэвтрүүлэх үүрэгтэй.

3.3.9. Тооцооны байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд оролцогчдыг тооцооны байгууллагын үйлчилгээтэй холбоотой зардал, эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай мэдээллээр хангаж ажиллана.

3.3.10. Тооцооны байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг бүртгэж хөтөлнө.

3.3.11. Тооцооны байгууллага нь Хороо болон олон нийтэд дараах мэдээллийг хүргэнэ:

3.3.11.1. тооцооны байгууллагаас хийсэн бүх гэрээ, хэлцэл болон гүйлгээний төлбөр, тооцооны талаарх мэдээлэл;

3.3.11.2. тооцооны байгууллагын гишүүн болон харилцагчдаас авч буй тооцооны болон бусад шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл;

3.3.11.3. маржинг тооцоолох аргачлал болон тооцооны байгууллагын төлбөрийн баталгааны сангийн хөрөнгийн хэмжээ болон бүрдэл;

3.3.11.4. тооцооны байгууллагаас хийсэн бүх гэрээ бүрийн өдрийн тооцооны үнэ, хэмжээ, нээлттэй позицийн талаар.

Дөрөв. Арилжаа эрхлэх байгууллага, тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллага, бусад зохицуулалттай этгээдэд тавигдах шаардлага

4.1. Арилжаа эрхлэх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны програм хангамж, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

4.1.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэхэд шаардлагатай мэргэшсэн боловсон хүчинтэй байх;

4.1.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэх нэгжтэй байх;

4.1.4. үүсмэл санхүүгийн хэрэгслийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах боломжийг судлах, үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээний загварыг боловсруулах нэгжтэй байх;

4.1.5. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг хянах нэгжтэй байх;

4.1.6. үүсмэл санхүүгийн арилжаа эрхлэхтэй холбоотойгоор Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний шаардлагыг хангасан байх;

4.1.7. үнийн санал болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаатай холбоотой мэдээллийг бүртгэх, түгээх, нийтэд ил тод мэдээлэх үр дүнтэй тогтолцоотой байх;

4.1.8. мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чадвартай байх;

4.1.9. системийн тасралтгүй ажиллагааны зохицуулалт буюу онцгой байдлын төлөвлөгөө, нөөц төв, түүний техникийн зохистой үзүүлэлтийг хангасан байх.

4.2. Арилжаа эрхлэх байгууллага нь дараах үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталж, нийтэд мэдээлнэ:

4.2.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг зохион байгуулах тухай;

4.2.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээний загварыг бүртгэх үйл ажиллагааны тухай;

4.2.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд хяналт тавих тухай;

4.2.4. үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх тухай;

4.2.5. үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд оролцогчдын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

4.2.6. харилцагчийн хөрөнгөтэй харилцах, хамгаалах, хяналт тавих тухай;

4.2.7. системийн аюулгүй үйл ажиллагаа, найдвартай байдлыг хангах, давагдашгүй хүчин зүйлийн үед авах арга хэмжээний тухай;

4.2.8. онцгой нөхцөл байдалд авах арга хэмжээний тухай;

4.2.9. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэх байгууллагын гишүүнд тавигдах шаардлага шалгуурын тухай;

4.2.10. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах;

4.2.11. шаардлагатай бусад дүрэм, журам.

4.3. Арилжаа эрхлэх байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээ болон арилжаа эрхлэх байгууллага дээрх үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаатай холбоотой гарсан аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх зохицуулалттай байна.

4.4. Арилжаа эрхлэх байгууллага нь өөрийн бүртгэлийн болон үйл ажиллагааны шаардлага, шалгуурыг хангаагүй, түүний өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гишүүн байгууллагыг өөрийн бүртгэлээс хасахаар шийдвэрлэсэн бол тухайн шийдвэртэй холбоотой бүхий л баримт материалыг шийдвэр гарсан өдөртөө Хороонд хүргүүлж мэдэгдэнэ.

4.5. Арилжаа эрхлэх байгууллага нь гишүүн байгууллагаас гомдол гарсан тохиолдолд аливаа шийдвэрийг гаргахаасаа өмнө тухайн гомдлыг үндэслэлтэй эсэхийг нягталж хянасан байх ба уг асуудалтай холбоотой нэмэлт тайлбар, шаардлагатай мэдээллийг гишүүн байгууллагаас шаардаж, тэдгээрт үндэслэн асуудлыг шийдвэрлэсэн байна. Гишүүн байгууллагаас ирүүлсэн гомдолтой холбоотой бүх баримт материалыг Хороонд хүргүүлнэ.

4.6. Тооцооны байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

4.6.1. тооцооны үйл ажиллагааг тасралтгүй явуулах программ хангамж, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

4.6.2. тооцооны үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний шаардлагыг хангасан байх;

4.6.3. тооцооны үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэшсэн боловсон хүчний нөөцтэй байх;

4.6.4. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны төлбөрийн баталгааны санг бүрдүүлж ажиллах;

4.6.5. үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлтэй холбоотой системийн эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх нэгжтэй байх;

4.6.6. гишүүн байгууллагуудын санхүүгийн нөхцөл байдал ба үүсмэл санхүүгийн хэрэгслийн позицод хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоотой байх;

4.6.7. тооцооны системээр дамжиж байгаа болон хадгалагдаж буй мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чадвартай байх;

4.6.8. системийн тасралтгүй ажиллагааны зохицуулалт буюу онцгой байдлын төлөвлөгөө, нөөц төв, түүний техникийн зохистой үзүүлэлтийг хангасан байх.

4.7. Тооцооны байгууллага нь дараах үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталж, нийтэд мэдээлнэ.

4.7.1 үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны үйл ажиллагааны тухай;

4.7.2 үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны маржинг тооцоолох, маржин хэлбэрээр байршуулсан барьцаа хөрөнгийн төрөл зүйл, барьцаа хөрөнгийн найдвартай хадгалалт, хамгаалалтын тухай;

4.7.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны төлбөрийн баталгааны санг бүрдүүлэх, захиран зарцуулах тухай;

4.7.4 тооцооны гишүүний төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд авах арга хэмжээний тухай;

4.7.5. үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны үйл ажиллагаанд хяналт тавих;

4.7.6. үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах;

4.7.7. үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх;

4.7.8. үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд оролцогчдын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

4.7.9. онцгой нөхцөл байдалд авах арга хэмжээний тухай;

4.7.10. системийн аюулгүй үйл ажиллагаа, найдвартай байдлыг хангах, давагдашгүй хүчин зүйлийн үед авах арга хэмжээний тухай;

4.7.11. үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллагын гишүүнд тавигдах шаардлага, шалгуурын тухай;

4.7.12. шаардлагатай бусад дүрэм, журам.

4.8. Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага дараах шаардлагыг хангасан байна:

4.8.1. Брокер, дилер нь Хорооноос тогтоосон журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан зохицуулалттай этгээд байна.

4.8.2. Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх захирлыг Хорооноос тогтоосон журмын дагуу Хорооны зөвшөөрлөөр томилно.

4.8.3. Брокер, дилер нь харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлаж, харилцагч тус бүрт өөрийнхөө данснаас тусад нь данс нээж харилцагчийн хөрөнгийг хадгална.

4.8.4. Брокер, дилерийн өр төлбөрийг харилцагчийн хөрөнгөөр барагдуулахаас сэргийлэх дотоод хяналтын тогтолцоотой байна.

4.8.5. Брокер, дилер нь харилцагчийн нэрийн өмнөөс үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд зориулж данс нээхийн өмнө тухайн арилжааны эрсдэл, түүнээс үүсэх үр дагаврын талаарх мэдэгдлийг харилцагчид хүргүүлж, тухайн харилцагчаас уг мэдэгдлийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгийг гаргуулан авна.

4.8.6. Брокер, дилер нь дансны бүх гүйлгээ, төлбөр хураамж, орлогын талаарх мэдээллийг агуулсан дансны хуулгыг харилцагчид сар бүр тогтмол гаргаж өгнө.

4.8.7. Брокер, дилер нь харилцагчийн нэрийн өмнөөс хийсэн арилжааны бүх баталгаажуулалт, цэвэр ашиг болон алдагдлын талаарх мэдэгдлийг тухайн арилжааны дараагийн өдөрт багтаан харилцагчид цахимаар мэдэгдэнэ.

4.8.8. Брокер, дилерийн нь харилцагч тус бүрийн эрх үүрэгт үнэ цэнийн хязгаарлалт тавих ба уг хязгаарыг давсан тохиолдолд харилцагчийн өгсөн захиалгын дагуу хийсэн үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг цуцлах эрхтэй.

4.8.9. Брокер, дилер нь дараах шаардлагыг хангасан байна:

4.8.9.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг гүйцэтгэхэд шаардлагатай програм хангамж, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

4.8.9.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний шаардлагыг хангасан байх;

4.8.9.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэшсэн боловсон хүчинтэй байх;

4.8.9.4. арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх;

4.8.9.5. мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чадвартай байх.

4.8.10. Брокер, дилерийн компани нь дараах мэдээллийг хөтлөх, бүртгэх, хадгалах үүрэгтэй:

4.8.10.1. харилцагч тус бүрийн нэр, хаяг, ажил мэргэжил зэргийг хамруулсан тогтмол бүртгэл;

4.8.10.2. арилжааны бүхий л мэдээллийг хамруулсан бүрэн бүтэн, тогтмол бүртгэл;

4.8.10.3. харилцагчийн захиалгыг хүлээн авсан болон захиалга биелүүлэхээр шилжүүлсэн огноо, цагийн талаар бичмэл бүртгэл хөтлөх ба хэлцэл хариуцсан брокер нь биелэлтийн огноо, цагийн талаар бичмэл бүртгэл хөтөлнө;

4.8.10.4. харилцагч тус бүрийн санхүүгийн бүртгэлийн дэвтэр хөтлөх ба үүнд бүх арилжаа, орлого, зарлагын талаарх мэдээллийг тусгана;

4.8.10.5. үүсмэл санхүүгийн хэрэгслийн брокер, дилерийн компанийн ажлын өдөр бүр хийсэн бүх арилжааны мэдээллийг харуулсан бүртгэл;

4.8.11. Брокер, дилер нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлтэй холбоотой дараах үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталж, нийтэд мэдээлнэ.

4.8.11.1. брокер, дилерийн үйл ажиллагааны тухай;

4.8.11.2. дотоод хяналтын үйл ажиллагааны тухай;

4.8.11.3. харилцагчдыг эрсдлээс хамгаалах үйл ажиллагааны тухай;

4.8.11.4. харилцагч, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх тухай;

4.8.11.5. зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх тухай;

4.8.11.6. шаардлагатай бусад дүрэм, журам.

Тав. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгүүлэх хүсэлт гаргах

5.1. Арилжаа эрхлэх байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

5.1.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгүүлэх өргөдөл;

5.1.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээ;

5.1.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээг бүртгүүлэх, түүнд өөрчлөлт оруулах талаар эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

5.1.4. үүсмэл санхүүгийн хэрэгслийн танилцуулга болон түүний техник эдийн засгийн үндэслэл;

5.1.5. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэгт заасан хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэн үнэлэлт, дүгнэлт гаргасан бол тэдгээрийн дүгнэлт;

5.1.6. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт;

5.1.7. энэ журамд заасан бусад нэмэлт баримт бичиг.

5.2. Арилжаа эрхлэх байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгүүлэхээр Хороонд хүсэлт гаргасан бол танилцуулга болон техник эдийн засгийн үндэслэлдээ дараах мэдээллийг тусгана:

5.2.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл, түүний дотор тухайн гэрээний стандарт нөхцлүүдийг баталгаажуулж нотлох аливаа тоон өгөгдөл, мэдээ мэдээлэл;

5.2.2. суурь хэрэгслийн зах зээлийн бүрэн хэмжээний дэлгэрэнгүй судалгаа;

Энэхүү судалгаа нь суурь хэрэгслийн зах зээлтэй холбоотой олон нийтэд нээлттэй, баталгаат эх сурвалжаас гаргасан сүүлийн 3-аас доошгүй жилийн мэдээлэлд тулгуурласан байна. Судалгаанд ашигласан дээрх мэдээллийн эх сурвалжийг тодорхой зааж, баримтжуулсан байна.

5.2.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн эрэлт, нийлүүлэлт, эдийн засагт үзүүлэх хувь нэмэр, эрсдэлийн шинжилгээ, суурь бүтээгдэхүүний үнийг ирээдүйд тогтоох боломжийн талаарх судалгаа;

5.2.4. арилжаа эрхлэх байгууллага нь гэрээний загварыг боловсруулах явцдаа тухайн зах зээлд оролцогчидтой зөвлөлдөж, тэдний санал бодлыг хэлэлцүүлэг өрнүүлэх замаар авах, мөн хэлэлцүүлэг, хурал зөвлөгөөний үйл явцыг баримтжуулж, тухайн хэлэлцүүлэг зөвлөгөөнөөр хэлэлцэгдсэн бүх асуудал, тэдгээрээс гарсан саналуудыг нэгтгэсэн тайланг баримт нотолгооны хамт.

5.3. Биетээр хүргэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг боловсруулахдаа дараах зүйлийг тусгана:

5.3.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний нөхцөл нь суурь хэрэгслийн зах зээлийн нийтлэг үйл ажиллагаа, нөхцөл байдалд нийцсэн байна.

5.3.2. гэрээний хугацаа дуусах өдөр үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ болон суурь хэрэгслийн зах зээлийн үнэ нь тэнцэж байх, суурь хэрэгслийн хүргэлтэнд аливаа саатал учрахаас сэргийлэх шаардлагатай.

5.3.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, тогтмол хэмжээнд барихаас сэргийлэхийн тулд суурь хэрэгслийн нийлүүлэлтийн хэмжээг хангалттай хэмжээнд байлгах шаардлагатай.

5.4. Биет байдлаар хүргэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний загварт дараах зүйлсийг тусгана:

5.4.1. чанарын стандарт;

5.4.2. хүргэлтийн цэг, агуулах;

5.4.3. хүргэлтийн хугацаа, арилжааны сүүлчийн өдөр;

5.4.4. гэрээний хэмжээ, арилжих нэгж;

5.4.5. сав баглаа боодлын стандарт болон чанараас бусад стандарт;

5.4.6. хүргэлтийн баримт бичиг;

5.4.7. үзлэг, шалгалтын горим;

5.4.8. хүргэлтийн сар;

5.4.9. үнийн хамгийн бага хэлбэлзэл;

5.4.10. үнийн хамгийн их хэлбэлзэл;

5.4.11. позицид тавих хязгаарлалт;

5.4.12. хороонд мэдээлэх позицын хэмжээ;

5.4.13. арилжааны хуваарь;

5.4.14. арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон бусад.

5.5. Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийгдэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг боловсруулахдаа дараах зүйлийг тусгана:

5.5.1. Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийгддэг гэрээний үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, тогтмол хэмжээнд барихаас сэргийлж арилжаа эрхлэх байгууллага нь суурь хэрэгслийн зах зээлийн хэмжээ, хөрвөх чадварыг харгалзаж үзнэ.

5.5.2. Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийгдэх гэрээний үнийг арилжаа эрхлэх байгууллага тогтоохдоо үнийг зохиомлоор өсгөх, бууруулахаас сэргийлж тооцоолох аргачлалыг нийтэд ил тод байлгана.

5.6. Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийгдэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний загварт дараах зүйлсийг тусгана:

5.6.1. суурь хэрэгслийн тодорхойлолт;

5.6.2. гэрээний хэмжээ /contract size/, арилжих нэгж;

5.6.3. төлбөр тооцоо хийх горим;

5.6.4. суурь үнэ, үнийн хамгийн бага хэлбэлзэл;

5.6.5. үнийн хамгийн их хэлбэлзэл;

5.6.6. арилжааны сүүлчийн өдөр;

5.6.7. арилжааны сар;

5.6.8. позицид тавих хязгаарлалт;

5.6.9. хороонд мэдээлэх позицын хэмжээ;

5.6.10. арилжааны хугацаа;

5.6.11. арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон бусад.

Зургаа. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэх, бүртгэхээс татгалзах

6.1. Хороо нь энэхүү журмын дагуу бүрэн гүйцэд ирүүлсэн баримт бичгийг хянаж, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэхээс татгалзах үндэслэлгүй бол үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэх асуудлыг шийдвэрлэнэ.

6.2. Хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт заасан үндэслэлээр үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэхээс татгалзана.

6.3. Хороо нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэх тухай шийдвэрийг арилжаа эрхлэх болон тооцооны байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

6.4. Хороо нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг ямар нэгэн нөхцөл болзолтойгоор бүртгэхгүй.

6.5. Арилжаа эрхлэх байгууллага нь Хороонд бүртгүүлсэн үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээтэй холбоотой мэдээллийг нийтэд үнэ төлбөргүй хүргэх бөгөөд сонирхсон бүх этгээдийг танилцах боломжоор хангасан байна.

6.6. Хорооны бүртгэлд бүртгэгдсэн үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд тусгагдсанаас өөр агуулгатай мэдээлэл, нэмэлт мэдээлэл олон нийтэд түгээхийг хориглоно.

Долоо. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд өөрчлөлт оруулах, арилжааг зогсоох, бүртгэлээс хасах

7.1. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд өөрчлөлт оруулах шийдвэрийг арилжаа эрхлэх байгууллагын эрх бүхий этгээд гаргаснаас хойш ажлын 5 хоногийн дотор дараах баримт бичгийн хамт Хороонд хүргүүлнэ:

7.1.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд орох өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлт;

7.1.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд өөрчлөлт оруулах тухай эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

7.1.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд өөрчлөлт оруулах үндэслэл, тайлбар, судалгаа;

7.1.4. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

7.2. Хороо нь энэхүү журмын дагуу бүрэн гүйцэд ирүүлсэн баримт бичгийг хянаж, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу өөрчлөлтийг бүртгэхээс татгалзах үндэслэлгүй бол үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд орох өөрчлөлтийг бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

7.3. Хороо нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг дараах үндэслэлээр зогсооно:

7.3.1. биетээр хүргэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны хувьд суурь хэрэгсэл нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд заасан нөхцөлийг хангахгүй болсон нь тогтоогдсон;

7.3.2. дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох шаардлага үүссэн.

7.4. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэлээс хасуулах шийдвэрийг арилжаа эрхлэх байгууллагын эрх бүхий этгээд гаргаснаас хойш ажлын 5 хоногийн дотор дараах баримт бичгийн хамт Хороонд хүргүүлнэ:

7.4.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэлээс хасуулах тухай хүсэлт;

7.4.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэлээс хасуулах тухай эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

7.4.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг хасуулах үндэслэл, тайлбар, судалгаа;

7.4.4. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

7.5. Хороо нь энэхүү журмын дагуу бүрэн гүйцэд ирүүлсэн баримт бичгийг хянаж, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэлээс хасахад татгалзах үндэслэлгүй бол үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэлээс хасах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

7.6. Хороо нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг арилжаа эрхлэх болон тооцооны байгуулагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

Найм. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, дотоод мэдээлэл ашиглахыг хориглох

8.1 Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлийн оролцогч болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь үнэ ханшийг зохиомлоор тогтоох, өсгөж, бууруулах, харилцагчийг хууран мэхлэх замаар арилжаанд оролцуулах эсхүл оролцуулахгүй байх болон бусад арга хэлбэрээр үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлийг урвуулан ашиглах, мөн эдгээр үйлдэлд шууд болон шууд бус аргаар нөлөөлөхийг хориглоно.

8.2. Дараах нөхцөл байдлыг зах зээлийг урвуулан ашигласанд тооцно:

8.2.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн хэлцлийн төлбөр тооцоог хийх, хүлээн авах эсхүл суурь хэрэгслийг худалдан авах, худалдсаны дагуу төлбөр хүлээн авах, төлбөр хийх үүднээс банкинд хамтын данс нээх; эсхүл өөрийн банк дахь дансаа ашиглуулах;

8.2.2. тодорхой үүсмэл санхүүгийн хэрэгслийн болон суурь хэрэгслийн арилжаа идэвхитэй явагдаж байгаа мэт олон давтамжтай хэлцлүүдийг зах зээлийн оролцогчдыг төөрөгдүүлэх зорилгоор үгсэн тохиролцож арилжаанд оролцохоор захиалга өгөх, суурь хэрэгслийг худалдах, худалдан авах, хүргэх, төлбөр тооцоог хийх, хүлээн авах, барьцаа байршуулах;

8.2.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн хэлцлийн төлбөр тооцоог хийх, хүлээн авах эсхүл суурь хэрэгслийг худалдан авах, худалдсанаас үүссэн үр өгөөжийг хүртэх эсхүл өр төлбөрийг төлөх үүргийг бусад этгээдэд хүлээлгэх.

8.3. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн позицоос ашиг олох зорилгоор тухайн үүсмэл санхүүгийн хэрэгслийн суурь хэрэгслийн эрэлт, нийлүүлэлтэнд нөлөөлөх замаар үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэ ханшид нөлөөлөхийг хориглоно.

8.4. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан олон нийтийг төөрөгдөлд оруулсан, бодит бус хуурамч мэдээлэл цацах, амлалт өгөх замаар үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэ ханшинд нөлөөлөхийг хориглоно.

8.5. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэ ханшийг урьдчилан тодорхойлсон судалгаа, шинжилгээг хийхдээ бодит бус, буруу ташаа мэдээлэл ашиглахыг хориглоно.

8.6. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлд оролцогч нь дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, оролцохыг санал болгох, ятгах, бусдад дотоод мэдээллийг задруулахыг хориглоно.

Ес. Хороонд мэдээлэл хүргүүлэх

9.1. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалттай зах зээлд оролцогчид нь Хорооны 2013 оны 457 дугаар тогтоолоор батлагдсан “Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам”-аас гадна дараах мэдээллийг Хороонд ирүүлнэ. Үүнд:

9.1.1. үйл ажиллагааны журам, харилцагчтай хийсэн гэрээнд орсон нэмэлт өөрчлөлтийг өөрчлөлт орсноос хойш ажлын хоёр өдрийн дотор;

9.1.2. үйл ажиллагааны шимтгэл хураамжийн хувь, хэмжээнд өөрчлөлт орсон бол шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор;

9.1.3. тооцооны байгууллага нь тооцооны гишүүн төлбөрийн чадваргүй болсны улмаас түүний төлвөл зохих төлбөрийг барагдуулсан тохиолдолд болон тухайн төлбөрийн чадваргүй болсон этгээдийн талаарх мэдээллийг тухай бүр;

9.1.4. санхүүгийн тайланг улирал бүр Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд;

9.1.5. хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор;

9.1.6. стресс тестийн үр дүн, эрсдэлийн удирдлагын тайланг улирал бүр дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор;

9.1.7. зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцсон тохиолдолд мэдээллийг тухай бүр;

9.1.8. шаардлагатай тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр хүргүүлэх.

Арав. Хариуцлага

10.1. Хороо энэ журам болон холбогдох хууль, тогтоомжийн биелэлтэнд хяналт тавьж, илэрсэн зөрчилд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--oOo--